

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-137-ГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> /23 хуудас NZ Part 137-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.7-д үндэслэсэн/</p>	<p align="center">Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн Үйл ажиллагаа – гэрчилгээжүүлэлт <i>(Хүчинтэй мөрдөгдөж байгаа)</i> /12 хуудас (үндсэн дүрэм-22 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.2</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>137.1. Зорилго Энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно: (1) ИНД-91-д заасан нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн нэмэлт шаардлагаас гадна ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгчид тавих нэмэлт шаардлага; (2) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгчид тавих, ИНД-91-ийн нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн үл хамаарах шаардлага; (3) ХАА-н агаарын хөлгөөр арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны зохицуулалтын шаардлага.</p>	<p>137.1. Зорилго (а) Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх, хөдөө аж ахуйн нислэгийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.3. Нисгэгчийн мэргэшил (а) Агаараас бордоо цацах, агаараас шингэн цацах, эсхүл агаараас хортон мэрэгчийн хор цацах зорилгоор ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисгэгч нь ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй тохирох ХАА-н зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй. (б) Энэ зүйлийн (а)-г үл харгалзан, хэрэв ИНД-61-ийн дагуу олгосон Е Категорийн багш нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтын дор агаараас бордоо цацах, агаараас шингэн цацах, эсхүл агаараас хортон мэрэгчийн хор цацах ХАА-н сургалт хийж байгаа бол, тухайн нисгэгчийг ХАА-н зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.</p>	<p>137.3. Ерөнхий шаардлага (а) Энэ дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд Хөдөө аж ахуй /цаашид ХАА гэх/-н нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй. (б) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь: 1/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлгийн ангиллын хувьд ИНД-61-ийн дагуу олгогдсон ХАА-н хүчин төгөлдөр зэрэглэлтэй; эсхүл 2/ Е ангиллын багш нисгэгчийн удирдлага дор ХАА-н зэрэглэлийн хувьд дадлага авч, дараах нислэгүүдийг гүйцэтгэсэн туршлагатай байна: 2.1 хөдөө аж ахуйн бараа материал тээвэрлэх, түгээх нислэг; 2.2 тариан талбай, ой мод, гол мөрөн дээгүүр 150 м (500 фут)-ээс доош өндөрт үйлдэх нислэг; 2.3 мал, амьтан тээвэрлэх болон өвс тэжээл хаяж өгөх нислэг. 3/ ХАА-н зориулалттай химийн бодис цацах бол ИНД-61-ийн дагуу олгогдох химийн зэрэглэлтэй байна.</p>	<p>-Amend.6-аар өөрчлөгдсөн</p> <p>-Зохиомол</p>
<p>137.5. Гэрчилгээний шаардлага Энэ Дүрмийн D Бүлгийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр</p>		

<p>үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний эрх болон нөхцөлд заагаагүй тохиолдолд аливаа этгээд нь ХАА-н агаарын хөлгөөр арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.7. Нөөц</p>		
<p>137.9. Осол, зөрчил <u>Осол, эсхүл зөрчилд өртсөн</u> ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь ИНД-12-ын дагуу тухайн осол, эсхүл зөрчлийг <u>Даргад</u> мэдээлэх үүрэгтэй.</p>	<p>137.5. Осол, зөрчлийн талаар мэдээлэх (а) <u>Аливаа этгээд</u> ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбогдолтой осол, зөрчлийн талаар ИНД-12-т заасны дагуу мэдэгдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг - Нислэгийн дүрэм</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖИЛТ</p>	
<p>137.51. Зорилго Энэ Бүлэг нь, ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгчид ИНД-91-д заасан нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн үл хамаарах шаардлага болон нэмэлт шаардлагыг тогтооно.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.53. Хүчингүй</p>	<p>137.151. Химийн бодис цацах (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр химийн бодис цацахдаа дараах зүйлийг мөрдлөг болгоно: 1/ тухайн бодисыг зориулалтын дагуу ашиглах, 2/ тухайн бодисын шошгон дээрх аюулгүй ажиллагааны заавар, хязгаарлалтын дагуу ажиллах. (б) Нислэгийг, судалгаа шинжилгээ, туршилтын зорилгоор, эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлтэй үйлдэж байгаа бол энэ зүйлийн (а)-д заасныг мөрдөхгүй байж болно.</p>	<p>-Amend.1-ээр хүчингүй болсон</p>
<p>137.55. Аэродром дээр эргэлт хийх чиглэл ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч нь дараах тохиолдолд тухайн аэродромд буухаар ойртолт үйлдэж байхдаа эсхүл хөөрөлт үйлдсэний дараа ИНД-91-д зааснаас өөр чиглэлд эргэлт хийж болно, хэрэв: (1)тухайн аэродром нь зөвхөн ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашиглагддаг бол, эсхүл (2)тухайн аэродромоос ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгааг харуулах, ИНД-91-д заасан газрын дохио байрлуулсан бол.</p>	<p>137.153. Аэродром дээрх эргэлтийн чиглэл (а) Аэродром нь зөвхөн ХАА-н зориулалттай агаарын хөлөгт зориулагдсан, эсхүл агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа нь тухайн аэродромоос зохицуулагдаж байгааг заасан газрын дохиололтой бол ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр дадлагын болон ХАА-н зориулалттай нислэг үйлдэх нисгэгч нь буухын өмнөх ойртолт, эсхүл хөөрөлтийн дараа эргэлт үйлдэхдээ ИНД-91-ийн заалтыг мөрдөхгүй байж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.57. Хүчингүй</p>	<p>137.155. Аэродром дээрх эргэлтийн өндөр. (а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь дараах тохиолдолд хөөрөлтийн дараа эргэлт үйлдэхдээ ИНД-91-д заасан өндрийг баримтлахгүй байж болно: 1/ эргэлт хийсний дараа хүн ам суурьшсан бүс дээгүүр нисэхгүй бол; 2/ тухайн аэродром нь зөвхөн ХАА-н зориулалттай агаарын хөлөгт ашиглагддаг, нислэгийн удирдагч зөвшөөрсөн, эсхүл агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа нь тухайн</p>	<p>-Amend.3-аар өөрчлөгдсөн</p>

	аэродромоос зохицуулагдаж байгааг заасан газрын дохиололтой бол.	
137.59. Хүчингүй	137.59. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх (а) ИНЕГ-ын дарга нь аливаа этгээдийг энэхүү дүрмийн шаардлагаас ИНД-11-д заасны дагуу чөлөөлж болно.	-Amend.3-аар өөрчлөгдсөн
137.61. Шигүү суурьшлын бүс дээгүүрх нислэгийн үйл ажиллагаа ИНД-91-ийг үл харгалзан, хот,сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисгэгч нь дараах тохиолдолд тухайн үйл ажиллагааг бүрэн гүйцэтгэх зорилгоор ИНД-91-д заасан минимум өндрөөс доогуур нисэж болно, хэрэв: (1) нисгэгч тухайн үйл ажиллагааг Засгийн газрын аливаа байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэж байгаа бол; (2) нисгэгч тухайн үйл ажиллагааг Даргын тогтоосон нөхцөл хязгаарлалтын дагуу гүйцэтгэж байгаа бол; (3) нисгэгч тухайн үйл ажиллагааг энэ Дүрмийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа бол; (4) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 137.205-ын шаардлагыг хангаж байгаа бол.	137.159. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүр нислэг үйлдэх (а) Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь дараах тохиолдолд хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэр дээгүүр ИНД-91-д заасан хамгийн бага өндрөөс доогуур нислэг үйлдэж болно: 1/ нислэгийн нөхцөл, хязгаарлалтыг ИНЕГ-аас тогтоосон бол; 2/ ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаанд 137.105-ын заалтыг дагаж мөрдөх бол.	-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан
137.63. Шигүү бус суурьшлын бүс дээгүүрх нислэгийн үйл ажиллагаа (а) ИНД-91.311(а)(2)-ыг үл харгалзан, хот,сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүсээс бусад бүсийн дээгүүр ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч нь тухайн гадаргуугаас дээш аливаа өндөрт болон саадаас аль ч зайд нисэж болно, хэрэв: (1) нисгэгч тухайн үйл ажиллагааг гадаргуу дээр байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүйгээр гүйцэтгэх боломжит арга хэмжээ авсан бол; (2) ойртолт үйлдэх, эргэлт хийх болон нисэн гарах үеийн нислэгийн өндөр саадаас барих зай нь тухайн үйл ажиллагааг үр дүнтэй, аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай зайнаас бага биш бол. (b)ИНД-91.311(а)(2)-ыг үл харгалзан, хот,сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүсээс бусад бүсийн дээгүүр ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч нь дараах тохиолдолд ачаалах талбай болон холбогдох ажлын талбайн хооронд, эсхүл нэг ажлын талбайгаас дараагийн ажлын талбайн хооронд ИНД-91.311(а)(2)-т шаардсанаас нам	137.161. Хүн ам шигүү суурьшсанаас бусад газар нутаг дээгүүр нислэг үйлдэх (а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь дараах тохиолдолд ИНД-91-д заасныг үл харгалзан, аливаа саадаас ямар ч өндөр болон зайд нислэг үйлдэж болно: 1/ хүн ам суурьшаагүй газар нутаг дээгүүр нисэх бол; 2/ газар дээрх хүн болон эд зүйлст аюул учруулахааргүй бол; 3/ ойртолт, эргэлт, хөөрөлт үйлдэж байгаа өндөр, зай нь нислэгийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж байгаа бол.	-Amend.6-аар нэмэгдсэн

<p>өндөрт нисэж болно, хэрэв:</p> <p>(1) тухайн зай нь 9.3 км-ээс (5 nautical miles) бага бол;</p> <p>(2) нисгэгч тухайн нислэгийг гадаргуу дээр байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахааргүй үйлдэх боломжит арга хэмжээ авсан бол.</p>		
<p>137.65. Түлшний нөөц ИНД-91-ийг үл харгалзан, ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр <u>сургалт</u> хийж байгаа нисгэгч нь тухайн агаарын хөлөг дараах <u>минимум</u> түлшний нөөцтэй болохыг бататгах үүрэгтэй.</p> <p>(1) нисэх онгоцны хувьд 30 минутын нислэгийн <u>цаг</u>;</p> <p>(2) нисдэг тэрэгний хувьд урьдчилан <u>тооцоолсон</u> нислэгийн цагаас 3 дахин их, эсхүл 30 минутын нислэгийн цагийн аль багыг.</p>	<p>137.163. Түлшний нөөцийг <u>тооцох</u> (а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь ИНД-91-д заасныг үл харгалзан, тухайн агаарын хөлгийн хамгийн <u>бага</u> түлшний хэмжээг дараах байдлаар тооцно:</p> <p>1/ онгоцны хувьд нислэгийн 30 минут байхаар;</p> <p>2/ нисдэг тэрэгний хувьд дараах хугацааны аль багаар:</p> <p>2.1 нислэгийн 30 минут, эсхүл</p> <p>2.2 нислэгийн цагийн урьдчилсан <u>тооцооноос</u> 3 дахин их хугацаа.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>С Бүлэг - Тусгай нислэгийн дүрэм</p>	<p>В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА</p>	
<p>137.101. Зорилго Энэ Бүлэг нь ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааны зорилгоор, ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу хязгаарлалттай категорийн НТЧ-ын гэрчилгээ олгосон нисэх онгоцоор ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгчид ИНД-91-д заасан нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн үл хамаарах шаардлагыг тогтооно.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.103. Хөөрөлтийн максимум жин (а) ИНД-91 болон энэ зүйлийн (b)-д заасныг үл харгалзан, ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааг нисэх онгоцоор гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч дараахаас бусад тохиолдолд, тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан МСТOW-ээс дээш жинтэйгээр хөөрөлтийг үйлдэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн нисгэгч Хавсралт В-д заасан журмыг мөрдөж байгаа;</p> <p>(2) нисэх онгоцыг нисгэгч жэттисоны ажиллагааг эхлүүлснээс хойш 5 секундийн дотор тухайн нисэх онгоцны хуурай бодисын савны максимум даацын 80-аас багагүй хувийг цацах чадалтай D.5-н дагуу жэттисон системээр тоногдсон байх.</p> <p>(b) Хавсралт А-д заасан гуравдагч этгээдийн эрсдэл байгаа тохиолдолд нисгэгч 137.107 болон 137.109-н дагуу хөөрөлтийн максимум жинг тодорхойлох үүрэгтэй.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.105. Гуравдагч этгээдэд эрсдэлгүй хөөрөлтийн зай болон нислэгийн зам</p>	<p>137.205. Хөөрөлтийн зай ба нислэгийн зам (Гуравдагч талын эрсдэлгүй)</p>	

<p>Хавсралт А-д заасан гуравдагч этгээдийн эрсдэл байхгүй тохиолдолд, ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааг нисэх онгоцоор гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгчийг дараах шаардлагыг мөрдөхийг шаардахгүй:</p> <p>(1) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хөөрөлтийн зай;</p> <p>(2) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан, хөөрөлтийн нислэгийн замын налуу (gradient).</p>	<p>(a) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь энэ дүрмийн Хавсралт А-д заасан гуравдагч талын эрсдэлгүй тохиолдолд ИНД-91-ийг үл харгалзан, дараах зүйлийг мөрдөхгүй байж болно:</p> <p>1/ тухайн агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын зааварт заагдсан хөөрөлтийн зай;</p> <p>2/ тухайн агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын зааварт заагдсан хөөрөлтийн замын градиент.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.107. Гуравдагч этгээдэд эрсдэлтэй хөөрөлтийн зай</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Хавсралт А-д заасан гуравдагч этгээдийн эрсдэл байгаа тохиолдолд нисэх онгоцоор ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч хөөрөлтийн боломжит зай нь (TODA) тухайн нисэх онгоцны нислэгийн зааварт заасан хөөрөлтийн зайг 1.2 дахин үржүүлснээс их болохыг бататгах үүрэгтэй.</p> <p>(b) Нисгэгч хөөрөлтийн зайг тооцоолохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн нисэх онгоцны хөөрөлтийн гүйлт үйлдэж эхлэх үеийн жин;</p> <p>(2) тухайн аэродромын даралтын түвшин;</p> <p>(3) тухайн аэродромын орчны агаарын хэм;</p> <p>(4) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл нөхцөл;</p> <p>(5) хөөрөлт үйлдэх чиглэл дэх ХБЗ-ны налуу;</p> <p>(6) урдаас чиглэсэн салхины бүрдэл хэсгийн 50%-иас ихгүй, эсхүл араас чиглэсэн салхины, бүрдэл хэсгийн 150%-иас багагүй байх.</p>	<p>137.207. Хөөрөлтийн зай (Гуравдагч талын эрсдэлтэй)</p> <p>(a) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь энэ дүрмийн Хавсралт А-д заасан гуравдагч талын эрсдэлтэй тохиолдолд ИНД-91 ба энэ зүйлийн (б)-г үл харгалзан, хөөрөлт үйлдэх боломжит зай нь тухайн агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын зааварт заагдсан хөөрөлтийн зайнаас 1.2 дахин илүү гэдгийг магадлана.</p> <p>(б) Нисгэгч, хөөрөлтийн зайг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ:</p> <p>1/ агаарын хөлгийн хөөрөлтийн өмнөх жин;</p> <p>2/ гаднах агаарын хэм;</p> <p>3/ аэродромын өндрийн даралт;</p> <p>4/ хөөрөлт, буултын зурвасны гадаргуугийн төрөл байдал;</p> <p>5/ хөөрөх чиглэл дэх зурвасны налуу;</p> <p>6/ угтах салхины, эгц урдаас чиглэсэн, бүрдэл хэсэг 50%-иас ихгүй байх; эсхүл арын салхины, эгц араас чиглэсэн, бүрдэл хэсэг 150%-иас багагүй байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.109. Гуравдагч этгээдэд эрсдэлтэй хөөрөлтийн нислэгийн зам</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Хавсралт А-д заасан гуравдагч этгээдийн эрсдэл байгаа тохиолдолд нисэх онгоцоор ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр сургалт хийж байгаа нисгэгч тухайн хөөрөлтийн нислэгийн зам нь бүх саадаас дараах зайтай болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) босоо зай нь 15 м (50 ft) дээр нэмж 0.025D байхаас багагүй; эсхүл</p> <p>(2) хажуугийн хэвтээ зай нь 30 м дээр нэмж 0.1D байхаас багагүй “D” нь төгсгөлөөс агаарын хөлгийн гүйсэн замын дагуух хэвтээ зай.</p> <p>(b) Нисгэгч энэ зүйлийн (a)-ийн шаардлагыг хангах зорилгоор тооцоо хийхдээ дараах шаардлагыг харгалзан үзэх үүрэгтэй:</p>	<p>137.209. Хөөрөлтийн нислэгийн зам (Гуравдагч талын эрсдэлтэй)</p> <p>(a) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь энэ дүрмийн Хавсралт А-д заасан гуравдагч талын эрсдэлтэй тохиолдолд ИНД-91 ба энэ зүйлийн (б)-д заасныг үл харгалзан, хөөрөлтийн зам нь дараах чиглэлүүдэд аливаа саадгүй гэдгийг магадлана:</p> <p>1/ 150 метр (500 фут) дээр нэмэх 0.025D-гээс багагүй босоо зайд;</p> <p>2/ 30 м дээр нэмэх 0.1D-гээс багагүй хажуугийн зайд.</p> <p>“D”- хөөрөлтийн боломжит зайн төгсгөлөөс агаарын хөлгийн нисэн өнгөрүүлсэн замыг хэвтээ тэнхлэгт буулгасан урт.</p> <p>(б) Нисгэгч нь энэ зүйлийн (a)-д заасан зайг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ:</p>	<p>-(ft)-ийг буруу тооцоолсон</p> <p>-“Хэвтээ зайг” гэснийг “хажуугийн зай” гэж буруу</p>

<p>(1) тухайн хөөрөлтийн нислэгийн зам нь 137.107-д шаардсан хөөрөлтийн зайн төгсгөлд хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 м-ийн (50 ft) өндрөөс эхэлж, 150 м-ийн (500 ft) өндөрт дуусдаг байх;</p> <p>(2) тухайн нисэх онгоц нь 20°-аас хэтэрсэн өнцгөөр налуу эргэлт хийдэггүй байх;</p> <p>(3) төлөвлөсөн нислэгийн замаас 150 м-ээс их хажуугийн хэвтээ зайд байгаа саадыг тооцохгүй байж болох.</p>	<p>1/ хөөрөлтийн зам нь 137.207-д заагдсан хөөрөлтийн зайн төгсгөл дээрх хөөрөлтийн гадаргуугаас дээш 15 метр (50 фут)-ийн өндрөөс эхэлж 150 метр (500 фут)-ийн өндөрт төгсөнө;</p> <p>2/ агаарын хөлгийг 20 градусаас дээш өнцгөөр хазайлгаж болохгүй;</p> <p>3/ нислэгийн төлөвлөсөн замаас хажуу тийш 150 м-ээс цааш саад байж болно.</p>	<p>орчуулсан.</p>
<p>D Бүлэг - Арилжааны үйл ажиллагаа - Ерөнхий зүйл</p>	<p>Г БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ</p>	
<p>137.151. Гэрчилгээ эзэмших хүсэлт ХАА-н агаарын хөлгөөр арилжааны үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24137/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>137.51. Өргөдөл гаргах (a) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь ИНЕГ-0137/01 маягтыг бөглөж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>137.153. Гэрчилгээ олгох Хэрэв Дарга энэ Дүрмийн дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших эрхтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагч нь бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрмийн дагуу гүйцэтгэж чадахаа бататгах үүрэгтэй Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон удирдах ажилтныг үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр, ажиллуулдаг байх;</p> <p>(2) хүсэлт гаргагч нь Гүйцэтгэх захирлын өмнө дараах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан, эсхүл ажилтнуудыг үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр ажиллуулдаг байх:</p> <p>(i) нислэгийн үйл ажиллагаа болон газрын дэмжих үйл ажиллагааг багтаасан ХАА-н үйл ажиллагаанд (Ерөнхий нисгэгч);</p> <p>(ii) ИНД-137.155-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд;</p> <p>(2А) энэ зүйлийн (2)-т заасан удирдах ажилтан нь Хавсралт С-д заасан мэргэшил, ур чадварын болон туршлагын шаардлагыг хангасан байх;</p> <p>(3) хүсэлт гаргагч болон энэ зүйлийн (1) (2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүний шаардлагыг хангасан байх;</p> <p>(4) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>137.53. Гэрчилгээ олгоход тавигдах шаардлага</p> <p>(а) ИНЕГ-ын дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээ олгоно:</p> <p>1/ өргөдөл гаргагчийн зүгээс явуулах бүх үйл ажиллагаа энэ дүрмийн шаардлагын дагуу явагдаж, санхүүжиж байгааг батлан хариуцах эрх бүхий удирдах ажилтантай байх,</p> <p>2/ ИНД-61-ийн дагуу олгогдсон ХАА-н 1-р ангиллын багш нисгэгчтэй байх,</p> <p>3/ нислэгт тэнцэх чадвар (НТЧ) бүхий ХАА-н зориулалттай агаарын хөлөгтэй байх,</p> <p>4/ үйл ажиллагаа явуулахад шаардагдах удирдах болон инженер, техникийн ажилтнуудтай байх,</p> <p>5/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлах аливаа нөхцөл байдал үгүй байх.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.155. Аюулгүй байдлын удирдлага ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.</p>	<p>137.111. Аюулгүй ажиллагааны хяналт шалгалт</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн ашиглаж байгаа агаарын хөлгүүд, тоног хэрэгсэл, бичиг баримт, тайлан бүртгэлийн дотоодын хяналт шалгалтыг гүйцэтгэх ба ИНЕГ-аас шаардсан тохиолдолд дотоодын хяналт, шалгалттай хамааралтай мэдээллээ ирүүлнэ.</p>	<p>-Amend.5-аар өөрчлөгдсөн</p>
<p>137.157. Гэрчилгээний хүчинтэй хугацаа</p> <p>(а) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.</p> <p>(б) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ нь түүний хугацаа дуусах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.</p> <p>(с) гэрчилгээ эзэмшигч хугацаа нь дууссан, эсхүл хүчингүй болсон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн</p>	<p>137.55. Гэрчилгээний хугацаа</p> <p>(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээг 3 жилийн хугацаагаар олгоно.</p> <p>(б) Гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл ИНЕГ-аас үйлчлэлийг нь түр түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.</p> <p>(в) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээ эзэмшигч /цаашид Гэрчилгээ эзэмшигч гэх/ нь 1 (нэг)</p>	<p>-“Гэрчилгээг 3 жил” гэснийг “5 жил” хүртэл хугацаагаар олгоно</p>

<p>гэрчилгээг Даргад нэн даруй хураалгах үүрэгтэй.</p> <p>(d) Гэрчилгээ эзэмшигч нь түдгэлзүүлсэн ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээг зохих тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>жилийн хугацаанд ХАА-н зориулалттай нислэг үйлдээгүй бол гэрчилгээг хүчингүйд тооцно.</p> <p>(г) Гэрчилгээний хугацаа дууссан, түр түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээг ИНЕГ-ын даргад хураалгана.</p>	
<p>137.159. Гэрчилгээ сунгах</p> <p>(a) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24137/01 маягтын дагуу гаргах ёстой.</p> <p>(b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол, тухайн гэрчилгээний хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>137.57. Гэрчилгээний хугацааг сунгах</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь, ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээний хугацаа сунгуулах тухай өргөдлийг түүний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө ИНЕГ-0137/01 маягтын дагуу гаргаж ИНЕГ-ын даргад ирүүлсэн байна</p>	<p>-Хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулдаг байсныг 60-аас доошгүй хоног болгон уртасгасан</p>
<p>137.160. ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн аюулгүй байдлын удирдлагын баримт бичиг</p> <p>(a) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан баримт бичгийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) 137.155-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой дараах мэдээлэл:</p> <p>(i) 100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;</p> <p>(ii) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;</p> <p>(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны албан тушаал, нэр, үүрэг хариуцлага;</p> <p>(3) тухайн байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл.</p> <p>(b) Хүсэлт гаргагчийн байгууллагын Гүйцэтгэх захирал нь, байгууллагын нэрийн өмнөөс энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу гаргасан мэдээллийг бататган гарын үсэг зурсан дараах мэдэгдлийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) ИНД-100-гийн байнгын хэрэгжилтийг бататгах байгууллагын арга хэлбэрийг харуулсан;</p> <p>(2) ИНД-100-г дагаж мөрдөхийг шаардсан.</p>		<p>-Amend.5-аар нэмэгдсэн</p>
	<p>137.157. Навигацийн гэрэлгүй үйлдэх нислэг</p> <p>(a) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь дараах тохиолдолд ИНД-91-д заасныг үл харгалзан, нислэгийг навигацийн гэрэлгүйгээр үйлдэж болно:</p> <p>1/ нислэгийн ажиллагаанаас шалтгаалж түүнийг унтраах шаардлагатай ба энэ нь нислэгийн аюулгүй ажиллагаанд</p>	<p>-Amend.-3 аар хүчингүй болсон</p>

	<p>нөлөөлөхгүй бол; 2/ гэрэлтүүлэггүйгээр ил харагдах зүйлс нь 1850 метрээс доошгүй зайд харагдаж байгаа бол; 3/ хөөрөлт, буулт нь нислэгийн удирдагчийн зөвшөөрөл, хяналтын дор үйлдэгдэж байгаа бол; 4/ тухайн аэродромд өөр агаарын хөлгийн зохицуулалт хийгдээгүй бол.</p>	
<p>Е Бүлэг-Арилжааны үйл ажиллагааны шаардлага</p>	<p>Д БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ТУСГАЙ ЖУРАМ</p>	
<p>137.201. Бүртгэл хөтлөх (а) <u>ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн</u> гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг агуулсан үнэн зөв бүртгэлийг үйл ажиллагааны үндсэн байрлалдаа <u>хөтлөх</u> үүрэгтэй: (1) үйлчлүүлэгчийн нэр болон үйлчилгээ авсан хаяг; (2) <u>ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа</u> гүйцэтгэсэн өдөр; (3) <u>ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа бүрд тээвэрлэж, цацсан</u> материалын нэр болон тоо хэмжээ; (4) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисгэгчийн нэр, хаяг, нисгэгчийн үнэмлэхний дугаар болон зэрэглэлийн дэлгэрэнгүй мэдээлэл; (5) нисгэгч бүрд ХАА-н зэрэглэл олгосон хугацаа, эсхүл ИНД-61-ийн дагуу шаардсан, жилийн ур чадварын шалгалтыг амжилттай <u>өгсөн хугацааны аль сүүлд болсныг</u>; (6) хамааралтай бол, нисгэгч бүрд химийн зэрэглэл олгосон хугацаа, эсхүл ИНД-61-ийн дагуу шаардсан, сэргээх сургалтын <u>курст</u> амжилттай хамрагдсан хугацааны <u>аль сүүлд болсныг</u>. (б) Энэ зүйлийн (а)-д шаардсан бүртгэлийг, тухайн нислэгийн үйл ажиллагаа <u>дууссан өдрөөс хойш 2 жилээс доошгүй хугацаагаар хадгалах үүрэгтэй.</u></p>	<p>137.101. Бүртгэл <u>тэмдэглэлд тавигдах шаардлага</u> (а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлүүдийг агуулсан бүртгэл тэмдэглэлийг үйл ажиллагааны үндсэн байршилдаа <u>хадгална</u>: 1/ үйлчлүүлэгч (<u>захиалагч</u>)-ийн нэр хаяг; 2/ нислэгийн талаарх дэлгэрэнгүй бүртгэл; 3/ агаарын хөлөг бүрийн зөөвөрлөж, <u>түгээсэн</u> материалын нэр, тоо хэмжээ; 4/ ХАА-н <u>зориулалттай</u> агаарын хөлгөөр нислэг үйлдэж байгаа нисгэгчийн нэр, хаяг, мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлийн талаарх бүртгэл тэмдэглэл; 5/ ХАА-н зэрэглэл олгогдсон тухай, эсхүл ИНД-61-ийн дагуу ур чадварын шалгалт өгсөн тухай бүртгэл нисгэгч бүр дээр; 6/ ХАА-н химийн зэрэглэл олгогдсон тухай, эсхүл дадлага авсан тухай бүртгэл нисгэгч бүр дээр. (б) Дээрх бүртгэл, тэмдэглэлүүдийг нислэгийн үйл ажиллагаа дууссанаас хойш 12 сараас доошгүй хугацаагаар хадгална.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -бүртгэл, тэмдэглэлүүдийг 12 сараас доошгүй - 2 жилээс доошгүй хугацаагаар хадгална.</p>
<p>137.203. <u>Алслагдсан</u> баазаас үйлдэх нислэгийн <u>үйл ажиллагаа</u> Үйл ажиллагааны үндсэн бус баазаас үргэлжилсэн 14 хоног, эсхүл түүнээс дээш хугацаагаар <u>ХАА-н агаарын хөлгөөр арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг гэрчилгээ эзэмшигч нь тухайн баазыг хариуцсан дараах нисгэгчийг томилох үүрэгтэй</u>: (1) хүчинтэй ХАА-н зэрэглэл эзэмшдэг; (2) тухайн <u>алслагдсан</u> баазын үйл ажиллагаанд хариуцлага хүлээсэн; (3) <u>ээлжийн хуваарь</u> гаргах болон бүртгэл хөтлөх хариуцлага хүлээсэн.</p>	<p>137.103. <u>Үндсэн бус</u> баазаас нислэг үйлдэх (а) Үндсэн бус баазаас дараалсан 14 хоногоос дээш хугацаагаар ХАА-н нислэг үйлдэх нисгэгч нь: 1/ ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх <u>эрхтэй</u>, ХАА-н химийн зэрэглэлтэй байна; 2/ <u>үндсэн бус</u> баазаас үйлдэх нислэгийн үйл ажиллагааны <u>төлөө</u> хариуцлага хүлээнэ; 3/ тухайн газарт гүйцэтгэх <u>ажил үүргийг зохион байгуулах</u>, бүртгэл <u>мэдээ</u> хөтлөх, <u>бие даан шийдвэр гаргах чадвартай</u> байна.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>
<p>137.205. Шигүү суурьшлын бус дээгүүр үйлдэх нислэгийн үйл ажиллагаа</p>		

<p>(a) Хот, сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүс болон байгууллагад үйл ажиллагаатай холбоотой зааварчилгаа өгөх төлөвлөгөө гаргах;</p> <p>(2) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүс болон байгууллагад зааварчилгаа өгснийг бататгах;</p> <p>(3) тухайн үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд үр дүнтэй хэлбэрээр өгөх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)(1)-д шаардсан төлөвлөгөө нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:</p> <p>(1) тухайн нислэгт учирч болох саадын мэдээлэл;</p> <p>(2) ашиглаж байгаа агаарын хөлгийн онцгой нөхцөлийн буулт үйлдэх чадварын дэлгэрэнгүй мэдээлэл,</p> <p>(3) холбогдох НХУ-ын үйлчилгээнд шаардлагатай байж болох зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл.</p> <p>(c) Хот, сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн дарга энэ зүйлийн (a)(1)-д шаардсан төлөвлөгөөг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>(d) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь (a)(1)-ийн дагуу шаардсан төлөвлөгөөг нислэгийн үйл ажиллагаа дууссан өдрөөс хойш 2 жилээс доошгүй хугацаанд хадгалах үүрэгтэй.</p>		<p>-Amend.4-өөр нэмэгдсэн</p>
<p>137.207. Ажилтанд тавих шаардлага <u>ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа</u> эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 137.153(1) (2)-т заасан удирдах <u>ажилтныг</u> үндсэн <u>ажилтнаар үндсэн</u> гэрээгээр ажиллуулах үүрэгтэй.</p>	<p>137.107. Боловсон хүчний хангалт (a) Гэрчилгээ эзэмшигч нь 137.53-ын 1/-д заасан удирдах <u>албан тушаалтныг</u> гэрээгээр болон <u>хөлсөөр</u> ажиллуулна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.209. Үйл ажиллагааны өөрчлөлт ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) <u>САА 24137/01</u> маягтаар шаардсан мэдээллийн хүчинтэй байдалд нөлөөлөх өөрчлөлтийг <u>Даргад</u> бичгээр мэдэгдэх;</p> <p>(2) дараах өөрчлөлтийг хийхийн өмнө <u>Даргын зөвшөөрлийг</u> урьдчилан авах:</p> <p>(i) Гүйцэтгэх захирал, эсхүл <u>137.153(2)-т заасан этгээд</u>;</p> <p>(ii) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол.</p>	<p>137.109. Үйл ажиллагааны өөрчлөлт</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа орж байгаа аливаа өөрчлөлтийн талаар <u>ИНЕГ</u>-ын даргад бичгээр нэн даруй мэдэгдэнэ.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь удирдах албан тушаалтан, эсхүл ахлах нисгэгчээ өөрчлөх тохиолдолд <u>ИНЕГ</u>-ын даргад мэдэгдэж зөвшөөрөл авна.</p>	<p>-Amend.5-аар өөрчлөгдсөн</p>
<p>F Бүлэг - Хэрэглэл болон <u>төхөөрөмж</u></p>	<p>E БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БА <u>ТОНОГЛОЛ</u></p>	
<p>137.251. Зорилго Энэ Бүлэг нь энэ Дүрмийн дагуу ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн хэрэглэл болон</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан</p>


<p>төхөөрөмжид тавих ИНД-91-ийн нэмэлт шаардлагыг тогтооно.</p> <p>137.253. Ерөнхий зүйл Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа эхлүүлэхгүй: (1) тухайн агаарын хөлгийг ИНД-91 болон энэ Бүлгийн дагуу шаардсан тоо болон төрлийн хэрэглэл, төхөөрөмжөөр тоногдсон байх; (2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, төхөөрөмж нь дараах баримт бичигт заасан, холбогдох тодорхойлолт болон НТЧ-ын загварын стандартыг хангасан байх: (i) энэ Дүрмийн Хавсралт D; (ii) ИНД-21 Хавсралт C; (iii) ИНД-26; эсхүл (iv) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад орлох тодорхойлолт, эсхүл стандарт. (3) тухайн хэрэглэл болон төхөөрөмжийг агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварчилгаа, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад зааварчилгааны дагуу суурилуулсан байх; (4) тухайн агаарын хөлөгт ашиглах зорилгоор ИНД-91-ийн дагуу батласан MEL-д зааснаас бусад тохиолдолд агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл болон төхөөрөмж нь ажиллагаатай нөхцөлд байх.</p>	<p>137.251. Ерөнхий зүйл (a) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд нислэгийг эхлүүлж болохгүй: 1/ агаарын хөлөг нь шаардлагатай маяг, тоо ширхэг бүхий тоноглол, хэрэгслээр энэ бүлэг болон ИНД-91-д заасны дагуу тоноглогдоогүй бол; 2/ агаарын хөлөгт суурилагдсан тоноглол, хэрэгсэл нь дараах тодорхойлолт болон НТЧ-ын стандартад тохирохгүй бол: 2.1 энэ дүрмийн Хавсралт Г, 2.2 ИНД-21-ийн Хавсралт В, 2.3 ИНД-26, 2.4 ИНЕГ-аас баталсан нэмэлт тодорхойлолт, эсхүл стандарт. 3/ тоноглол, хэрэгсэл нь тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан заавар, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн зааврын дагуу суурилагдаагүй бол; 4/ тухайн агаарын хөлөгт ашиглагдах, ИНД-91-ийн дагуу батлагдсан Нислэгт зөвшөөрөгдөх хамгийн цөөн тоноглолын жагсаалт (MEL)-д тусгагдаагүй тоноглол, хэрэгсэл ажиллагаагүй бол.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.255. Суудал болон даруулга ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь, тухайн агаарын хөлгийн нисэх багийн гишүүдийн суудлыг мөрөвчит даруулгаар тоногдсон болохыг бататгах үүрэгтэй.</p>	<p>137.253. Суудал ба бэхэлгээ (a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн нисэх багийн гишүүдийн суудлыг мөрөвчит даруулга бүсээр тоногдсон байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.257. Нэмэлт хэрэглэл ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлгийг гулгалт заах хэрэглэлээр (slip indicator) тоногдсон болохыг бататгах үүрэгтэй.</p>	<p>137.255. Нэмэлт хэрэглэл (a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөгт халтиралт заагч (slip indicator) хэрэглэл суурилуулсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>137.259. Нэмэлт төхөөрөмж ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь, тухайн агаарын хөлгийг дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй: (1) зөвшөөрөгдсөн хуурай, эсхүл шингэн бодисын савны аль тохирохыг; (2) хуурай бодисын савны агууламжийн дээд түвшнийг нисгэгчид харуулах хэрэгсэл; (3) дотор талдаа хуурай, эсхүл шингэн бодисын саваар тоногдсон нисэх онгоцонд зориулсан жэттисон систем; (4) дараах мэдээллийг багтаасан Хавсралт D-гийн холбогдох</p>	<p>137.257. Нэмэлт тоноглол (a) Гэрчилгээ эзэмшигч, агаарын хөлөг бүрийг дараах тоноглолоор тоногдсон байна: 1/ шүршигч болон бункер сав; 2/ бункер саван дахь бодисны дээд түвшинг заагч; 3/ цацах төхөөрөмж суурилагдсан агаарын хөлгийн хувьд агаарын хөлгөөс гадагш цацах тоноглол; 4/ дараах агуулга бүхий зурагт хуудас:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>зурагт хуудас:</p> <p>(i) агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан хуурай, эсхүл шингэн бодисын савны максимум бүтцийн даац;</p> <p>(ii) зорчигчийн байрлал;</p> <p>(iii) нислэгийн хязгаарлалт;</p> <p>(iv) жэттисон хийх хүчин чадал.</p>	<p>4.1 бункер сав болон шүршигч савны хамгийн их ачаалал;</p> <p>4.2 зорчигчдын байрлал;</p> <p>4.3 нислэгийн хязгаарлалт;</p> <p>4.4 гадагш цацах төхөөрөмжийн агаарын хөлгөөс гадагш цацах хугацаа.</p>	
<p>137.301. ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилтийн үеийн зохицуулалт</p> <p>(a) Энэ дүрэм нь дараах этгээдэд хамаарна:</p> <p>(1)ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч;</p> <p>(2)ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.</p> <p>(b)Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах шаардлагыг мөрдөхийг шаардахгүй:</p> <p>(1)137.153(2)(ii);</p> <p>(2)137.155;</p> <p>(3)137.160(a)(1)(i);</p> <p>(4)137.160(a)(2);</p> <p>(5)137.160(a)(3);</p> <p>(6)137.160(b);</p> <p>(c) дагууХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 12 сарын 1 нээс өмнө. Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1)аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;</p> <p>(2)тухайн байгууллага, 137.155-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.</p> <p>(e)Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга:</p> <p>(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;</p> <p>(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн огноог тогтооно.</p> <p>(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тухайн хугацааг тогтоохдоо, Дарга дараах хүчин зүйлийг тооцох үүрэгтэй:</p>	<p>137.201. Үйлчлэх хүрээ</p>	<p>-Amend.5-аар нэмэгдсэн</p>

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- (4) аливаа гэрчилгээг сунгах хугацаа; ИНЕГ бүхий байгууллага, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 02 сарын 01-нээс хойш байж болохгүй.
- (g) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг гэрчилгээ сунгуулах хүсэлтийн хамт хүргүүлэх шаардлагагүй.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 02 сарын 01-нд хүчингүй болно.

Хавсралт А - Гуравдагч этгээдийн эрсдэл

Зураг 1-д үзүүлсэн хөөрөлтийн талбайд гуравдагч этгээдийн өмч, эсхүл гуравдагч этгээд өөрөө байгаа тохиолдолд гуравдагч этгээдийн эрсдэл байна.




Зураг 1

Хавсралт В – Хэт ачааллын жинг тодорхойлох

- (a) ИНД 137.103 (a)-д шаардсан нисгэгчийн журам дараах шаардлагаас бүрдэнэ:
 - (1) тухайн нисэх онгоцны нислэгийн заавар болон “нисэх онгоцны үндсэн даацын хязгаарын хүчин зүйлээс” МСТOW-г олох;
 - (2) Зураг 2-т үзүүлсэн графикийн хэвтээ тэнхлэг дээр “нисэх онгоцны үндсэн даацын хязгаарын хүчин зүйлийг” олж, түүнээс босоо шугам татан графиктай огтлолцсон цэгээс хэвтээ шугамаар босоо тэнхлэгтэй огтлолцох хамаарлаар тухайн жинг нэмэгдүүлж болох “максимум зөвлөсөн жингийн өсөлтийн хувийг” тогтоох ;
 - (3) үндсэн категорийн МСТOW-г дээрх хувиар нэмэгдүүлж, хөөрөлтийн шинэ максимум жинг олох;

ХАВСРАЛТ А. ГУРАВДАГЧ ТАЛЫН ЭРСДЭЛ

Зураг 1-д үзүүлсэн тогтоогдсон талбайд гуравдагч талын өмч, эсхүл гуравдагч тал өөрөө байгаа үед гуравдагч талын эрсдэл үүснэ.




Зураг 1.

ХАВСРАЛТ Б. ЖИНГИЙН ХЭТРЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ

- (a) 137.203-ын (a)-д зөвшөөрсөн, нисгэгчийн гүйцэтгэх журам дараах зүйлүүдээс тогтоно:
 - 1/ агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын заавраас хөөрөлтийн дээд жин болон агаарын хөлгийн ачааллын хязгаарыг олсон байх;
 - 2/ зураг 2-т үзүүлсэн графикийн хөндлөн тэнхлэг дээр онгоцны ачааллын хязгаарыг олоод, дээш босоогоор явуулж стандарт шугамтай огтлолцсон цэгээс босоо тэнхлэг дээрх хамаарал, жинг нэмэгдүүлж болох хамгийн их утгыг хувь (%) - иар олох;
 - 3/ дээрх нэмэгдэл утгыг нэмж хөөрөлтийн дээд жинг шинээр тодорхойлох;

-Орчуулга, найруулга зассан

-Орчуулга, найруулга зассан



Зураг 2

(б) Хөөрөлтийн шинэ **максимум** жингээр үйл ажиллагаа гүйцэтгэх эсэх шийдвэр гаргахдаа нисгэгч нь дараах хүчин зүйлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн аэродромын **даралтын түвшин**;
- (2) тухайн аэродромын орчны агаарын хэм;
- (3) тухайн ХБЗ-ны гадаргуугийн төрөл нөхцөл;
- (4) хөөрөлт үйлдэх чиглэл дэх ХБЗ-ны налуу;
- (5) хөөрөлт үйлдэх чиглэлийн урдаас болон араас чиглэсэн салхины бүрдэл хэсэг;
- (6) үйл ажиллагааны үзүүлэлтэд нөлөөлж болох бусад хүчин зүйл.


Хавсралт С

Хүснэгт С.1. ХАА-н үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан (ерөнхий нисгэгч)

Шаардлагатай баримт бичиг	Хүчинтэй 1-р Зэргийн ХАА-н зэрэглэл, эзэмшиж байсан, эсхүл эзэмшдэг байх. Хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг байх, хэрэв хамааралтай бол.
Туршлага	Гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны төрөлд хамааралтай, Даргын хүлээн зөвшөөрөхүйц дадлага туршлагатай байх.

Хүснэгт С.2. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

Ур чадвар	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвараа харуулах. Холбогдох ИНД болон аюулгүй байдлын
-----------	--



Зураг 2.

(б) Шинээр тодорхойлсон хөөрөлтийн **дээд** жинтэй нислэг үйлдэхдээ нисгэгч дараах хүчин зүйлүүдийг тооцсон байна:

- 1/ тухайн аэродромын **өндрийн даралт**;
- 2/ гаднах агаарын хэм;
- 3/ хөөрөлт, буултын зурвасны гадаргуугийн төрөл байдал;
- 4/ хөөрөлт үйлдэх чиглэл дэх зурвасны налуу;
- 5/ хөөрөлт үйлдэх чиглэл дэх угтах болон арын салхи;
- 6/ нислэгт нөлөөлж болох бусад хүчин зүйлүүд.

ХАВСРАЛТ В. ХЭРЭГЛЭЛ ТОНОГЛОЛЫН НТЧ

-Amend.5-аар нэмэгдсэн

	<p>удирдлагын шаардлагын талаар ажилласан мэдлэг туршлагатай байх.</p>		
<p>Туршлага</p>	<p>Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон тухайн байгууллагын ажиллагаатай холбоотой суурь мэргэжил болон туршлагатай байх.</p>		
<p>Хавсралт <u>D-Хэрэглэл болон төхөөрөмжийн НТЧ-ын загварын стандарт</u> F Бүлэгт шаардсан хэрэглэл төхөөрөмж нь дараах тодорхойлолт болон шаардлагыг хангасан байх ёстой.</p>	<p><u>Хийцийн стандарт</u> Бүлэг E-д заасан хэрэглэл, тоноглол нь дараах тодорхойлолт болон шаардлагуудыг хангасан байна:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>	
<p>D.1. Суудал болон даруулга</p>	<p>V.1 Суудал болон бэхэлгээ</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>	
<p>Суудал болон мөрөвчит даруулгыг урагш чиглэсэн 12g инерцийн хүчийг даахаар зохион бүтээсэн байх ёстой.</p> <p>D.2. Хүчингүй</p>	<p>Суудал болон аюулгүйн даруулга бүс нь урагш үүсэх 12 g инерцийн хүчийг тэсвэрлэхүйц хийцтэй байна.</p> <p>V.2 Бункерийн зөвшөөрөгдсөн хамгийн их ачаалал Бункерийн зөвшөөрөгдсөн хамгийн их ачаалал нь хөөрөлтийн хамгийн их ачаалал бөгөөд дараах жингүүдийн нийлбэрээс бага байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ агаарын хөлгийн ачаалалгүй үеийн /хоосон/ жин; 2/ нисэх багийн гишүүн тус бүрийг 77 кг-аар тооцсон жин; 3/ хөдөлгүүрийн чадлын дээд горимын 75% дээр 1цаг нисэхэд хүрэлцэхүйц түлшний жин; 4/ агаарын хөлгийн ачаалалгүй үеийн /хоосон/ жинг оруулан тооцсон тосны хэмжээ ба хөдөлгүүрийн тосны хамгийн их хэмжээ хоёрын зөрүү жин. 	<p>-Amend.3-аар хасагдсан</p>	
<p>D.3. Хуурай болон шингэн бодисын сав</p> <p>(а) Бүхээгт байгаа хүмүүсийг гэмтээж болох байрлалд суурилуулсан хуурай, эсхүл шингэн бодисын сав болон түүний бэхэлгээний бүтцийг багавтар ослын буулт үйлдэх үед урагшаа чиглэсэн 12g инерцийн хүчийг даахаар зохион бүтээсэн байх ёстой.</p> <p>(б) Нисэх багийн өмнө байрлуулсан хуурай, эсхүл шингэн бодисын сав болон түүний бэхэлгээний бүтэцийг дараах инерцийн хүчийг даахаар зохион бүтээсэн байх ёстой.</p> <ol style="list-style-type: none"> (1) ар талаасаа 1.5g; (2) хажуу талаасаа 1.0g. <p>(с) Энэ зүйлийн (а),(б)-гийн зорилгоор хуурай, эсхүл шингэн бодисын савыг агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан максимум даацаар дүүргэсэн байхаар тооцсон байх ёстой.</p>	<p>V.3 Бункер болон шүршигч сав</p> <p>(а) Ослын үед бункер болон шүршигч сав нь түүнийг ажиллуулж буй этгээдийг гэмтээхээргүй байрлалд, түүний суурь бэхэлгээний бүтэц урагш үүсэх 12 g инерцийн хүчийг тэсвэрлэхүйц хийцтэй байна.</p> <p>(б) нисэх багийн өмнө байрлуулсан бункер болон шүршигч савны суурь бэхэлгээний бүтэц дараах инерцийн хүчнүүдийг тэсвэрлэхүйц байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ арын 1.5 g 2/ хажуугийн 1.0 g <p>(в) Энэ хэсгийн (а) ба (б)-д заасныг баталгаажуулахын тулд бункер болон шүршигч савыг холбогдох Нислэгийн ашиглалтын зааврын хязгаарлалтанд заасан хамгийн их ачааллаар дүүргэсэн байхаар тооцно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>	
<p>D.4. Хуурай бодисын савны агууламжийн дээд түвшин Тухайн агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан хуурай бодисын савны максимум даацын хагасаас хэтэрсэн бүх</p>	<p>V.4 Бункерийн багтаамжийн дээд түвшин</p> <p>(а) Нисгэгч нь бункерийн багтаамжийн дээд түвшинг дараах байдлаар тодорхойлно:</p>		

<p>ачааллын хувьд, тээвэрлэхийг зөвшөөрсөн ХАА-н материалын нягтралыг тооцон, нисгэгч агууламжийн дээд түвшнийг тодорхойлоход зориулсан заах, эсхүл ажиглалт хийх хэрэгслээр хуурай бодисын сав тоноглогсон байх ёстой.</p>	<p>1/ заалтаар, эсхүл нүдээр харж, 2/ холбогдох Нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон хамгийн их ачааллын хагасаас илүү ачааллын хувьд, ХАА-н материалын нягтралтай хамааралтайгаар зөвшөөрөгдсөн түвшинд байхаар.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.5. Жэттисон систем (а) Жэттисон систем нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1)ажиллуулахад хялбар байх; (2)нисгэгч удирдлагыг идэвхжүүлсэн бол, тухайн удирдлагыг үргэлжлүүлэн барих шаардлагагүйгээр, бүх ачаалал бүрэн гүйцэд цацагдан гарахаар зохион бүтээгдсэн байх.</p> <p>(b) Жэттисон системийн хүчин чадлыг: (1)шалгах нислэгийн үед дараах байдлаар туршсан байх ёстой: (i) тухайн нислэгийн зааварт заасан бордооны максимум зөвшөөрөгдсөн даацтайгаар; (ii) тусгай нэмэлт төхөөрөмж суурилуулсан тохиолдолд, нэмэлт төхөөрөмж суурилуулсан үед ашигладаг ХАА-н материалын максимум зөвшөөрөгдсөн даацтайгаар. (2) нисэх онгоцны нислэгийн зааварт заасан байх ёстой.</p>	<p>B.5 Аваарын цацагч тоноглол (а) Цацагч тоноглол нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ 5 секундын дотор онгоцонд байгаа ХАА-н материалын хамгийн их ачааллын 80-аас доошгүй хувийг цацах; 2/ ажиллуулахад хялбар байх; 3/ нисгэгч, цацагчийн удирдлагыг байнга барьж байхааргүй, зөвхөн нэг удаагийн үйлдлээр бүрэн гүйцэд цацахуйцаар хийгдсэн байх; (б) Шалгах нислэгийн үед аваарын цацагчийн боломжийг шалгаж үзэх ба энэ үеийн бункерийн хамгийн их ачаалал нь холбогдох Нислэгийн ашиглалтын зааврын хязгаарлалтанд заасан хамгийн их ачааллаас хэтэрч болохгүй.</p>	<p>-D.6.5.-ийн АНХААРУУЛГА-д орсон</p>
<p>D.6. Тэмдэглэгээ <u>зурагт хуудас</u></p>	<p>B.6 <u>Тэмдэг</u>, тэмдэглэгээ</p>	
<p>D.6.1. Ерөнхий зүйл. (а) Тэмдэглэгээ <u>зурагт хуудсыг</u> нүдэнд <u>харагдахуйц</u> газарт хялбар арилахгүй, <u>гэмтэж өөрчлөгдөхгүй</u>, <u>халхлагдахгүй</u>, эсхүл <u>салж унахгүй</u> байхаар байрлуулсан байх ёстой. (b) Тэмдэглэгээ <u>зурагт хуудсанд</u> ашигласан нэгж нь холбогдох хэрэглэл, эсхүл тухайн агаарын хөлгийн нислэгийн зааварт заасантай ижил байх ёстой.</p>	<p>B.6.1. Ерөнхий зүйл. (а) <u>Тэмдэг</u>, тэмдэглэгээг нүдэнд <u>үзэгдэхүйц</u> газарт, арилахааргүй, <u>сүүдэрлэгдэхээргүй</u>, <u>хуурч унахааргүй</u> байрлуулсан байна. (б) <u>Тэмдэг</u>, тэмдэглэгээнд ашигласан нэгжүүд нь холбогдох <u>багаж</u> хэрэгсэл, эсхүл холбогдох Нислэгийн <u>ашиглалтын</u> зааварт заасантай адил байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.6.2. Хуурай, эсхүл шингэн бодисын савны максимум ачаалал Хуурай, эсхүл шингэн бодисын савны максимум даацыг харуулсан зурагт хуудас нь: (1) дараах байдлаар байрласан байх ёстой: (i) хуурай, эсхүл шингэн бодисын савны дүүргэгчийн дэргэд; (ii) хэвийн ачилтын байрлалаас бүтэн харагдахаар; (2) тухайн зөвшөөрөгдсөн хуурай бодисын савны максимум даацаас хэтрээгүй максимум даацыг үзүүлсэн байх ёстой.</p>	<p>B.6.2. Бункер болон шүршигч савны хамгийн их ачаалал Бункер болон шүршигч савны хамгийн их ачааллыг заасан тэмдэглэгээ нь: 1/ бункер болон шүршигч савны цэнэглэх цоргоны ойролцоо, бүрэн харагдахуйц байрлагдсан байна; 2/ зөвшөөрөгдсөн хамгийн их ачааллыг хэтрүүлж болохгүйг анхааруулсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.6.3. Жэттисоны хүчин чадал ИНД-137.259(3)-ын дагуу жэттисон системээр тоноглогсон ХАА-н нисэх онгоц нь нислэгийн бүхээгтээ нисгэгчид харагдахаар байрлуулсан дараах бичиглэлийг агуулсан зурагт хуудастай</p>	<p>B.6.3. Аваарын цацагч тоноглолын цацах хугацаа Агаарын хөлгийн бүхээгт, цацагдаж байгаа материалуудын аваарын үед цацагдах хугацааг үзүүлсэн тэмдэглэгээ байна.</p>	<p>-Amend.2- оор</p>

байх ёстой:

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Тухайн нисэх онгоцны **жэттисоны хүчин чадал** нь нисэх онгоцны **конфигураци** цацах материалын төрөл, нөхцөлөөс шалтгаалан өөр өөр байж болно.

D.6.4. Зорчигчийн байрлал

Агаарын хөлгийн гадна талаас **ил** харагддаггүй зорчигчийн байрлалын хувьд, тухайн зорчигчийн байрлалын дэргэд их биеийн гадна хоёр талд дараах **бүдүүвч** зургийг байрлуулсан байх ёстой.



Зураг 3 Цагаан суурьтай улаан гурвалжин дотор хар өнгийн дүрстэй.

D.6.5. Нисэх онгоцны нислэгийн хязгаарлалт

(а) Дараах бичиглэлийг агуулсан **зурагт хуудас, эсхүл зурагт хуудаснуудыг ХАА-н нисэх онгоцны нислэгийн бүхээгт нисгэгчид харагдахаар байрлуулсан** байх ёстой.

АНХААРУУЛГА

Энэ нисэх онгоцны МСТOW-ээс хэтэрсэн үйл ажиллагаа нь тухайн ашиглагдаж байгаа конфигурацийн хувьд, **5 секундийн дотор максимум зөвшөөрөгдсөн даацын 80%-иас доошгүй байх минимум жэттисон хүчин чадлыг шаардана.**


СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Энэ бол ХАА-н нисэх онгоц. Штопорыг багтаасан бүх азробатик маневр хийхгүй. Нислэгийн огцом маневр хийхээс зайлсхий.

НЭМЭГДСЭН

В.6.4. Зорчигчийн байрлал

Зорчигчдын байрлал агаарын хөлгийн гадна талаас харагдахгүй тохиолдолд агаарын хөлгийн их биеийн гадна, хоёр талд, зорчигчийн байрлалын ойролцоо зураг 3-т үзүүлсэн **диаграммыг** тэмдэглэсэн байна:



Зураг 3.

В.6.5. Нислэгийн хязгаарлалтууд

Дараах бичлэг бүхий **тэмдэглэгээг** агаарын хөлгийн бүхээгт байрлуулсан байна:

АНХААР

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр уран жолоодлого үйлдэхийг хориглоно. Нислэгийн огцом жолоодлогоос зайлсхий. Зөвшөөрөгдсөн **дээд жинг** бүү хэтрүүл. Зааврыг дагаж мөрдөхгүй байх нь агаарын хөлгийн ашиглалтын хугацааг богиносгох, улмаар осолд хүргэж болзошгүй.

-Орчуулга, найруулга зассан

-Amend.3-аар өөрчлөгдсөн